



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 1/190

Мөрөн сум

Цэрэг татлага зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12,13 дугаар зүйл, Аймгийн Засаг даргын 2024 оны А/165 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.2024 оны хоёр дугаар ээлжийн цэрэг татлагыг 2024 оны 10 дүгээр сарын 08 ний өдрийн 13.00 цагт явуулсугай

2.Цэрэг татлагыг зохион байгуулах Сумын комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Комиссын дарга:	Н.Намжилноров	Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүдэд:	Ж.Дашжамц	"Зөөлөн" багийн Засаг дарга
	Н.Амармөрөн	"Өлзийт" багийн Засаг дарга
	Т.Гүржав	"Бүрээт" багийн Засаг дарга
	Э.Балчиндорж	"Цагаан толгой" багийн Засаг дарга
	Д.Золзаяа	"Чандган" багийн Засаг дарга
	Б.Гандолгор	Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

3. Зарлан дуудах хуудсыг нэрсийн жагсаалтад орсон цэргийн албанд татагдагч бүрд хүргүүлэн, заасан хугацаанд Цэрэг татлагын байранд бэлэн байлгахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Сумын Ерөнхий боловсролын сургуулийн урлаг заалыг түшиглэн сумын Цэрэг татлагын байрыг зааврын дагуу бэлтгэж, Цэрэг татлагын товчоо, зохион байгуулах бүрэлдэхүүний ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийг комиссын дарга: (Н.Намжилноров), Ерөнхий боловсролын сургуулийн Захирал (М.Ариунаа) нарт даалгасугай.

5. Цэргийн албанд татагдагчдын гэмт хэрэг зөрчилд холбогдож байсан эсэхийг хянах, Цэрэг тээвэрлэх автомашинд үзлэг хийх, олон нийтийн аюулгүй байдал, хэв

журмын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг Цагдаагийн хэсгийн төлөөлөгч (Б.Итгэлсайхан)-д даалгасугай.

6. Сумын Цэрэг татлагын байрны галын аюулгүй байдлыг хангах, байнгын үзлэг шаргалт хийж ажиллахыг БНЗӨБЦТТӨХК-ийн Шуурхай үйлчилгээ, засварын монтер (Н.Пүрэвцэрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.БАТЦООЖ